

“ТАЛХ ЧИХЭР” ХК-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ 2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

“Талх-Чихэр” ХК -ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо нь 2020 оны санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан зэрэг эдийн засгийн үзүүлэлтэд аудит хийж, дүгнэлт гаргаж , хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

“Талх-Чихэр”ХК–ийн ТУЗ-ийн Аудитын Хорооны дүгнэлтийн үндэслэл нь компанийн дотоод хяналтын ажлын үйл явц, тэдгээрийг тодорхойлж байгаа үйлдэл зэрэгт хяналтын ажлын хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

Санхүүгийн тайланд тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зарчмууд, эдийн засгийн тооцоонуудыг санхүүгийн тайланд бодит байдалд нийцүүлж тусгасан эсэхэд дүгнэлт өгч, тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг урьд онтой зэрэгцүүлж тэдгээрийн өсөлт бууралтыг тодорхойлон харьцуулсан судалгааны тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд илтгэж байна.

Тус компанийн 2020 оны Санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг урьд онтой харьцуулсан судалгааг авч үзэхэд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны борлуулалт тайлант онд 63,054,2 сая төгрөг болж, урьд оноос 8,198,4 сая төгрөгөөр буюу 14,9% иар өссөн байна.
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 47,695,2 сая төгрөгт хүрч урьд оноос 6,809,4 сая төгрөг буюу 16,7%иар өссөн байна. Бусад зардал урьд оноос 249,6 сая төгрөгөөр буурсан байна. Борлуулалтын өртгийн өсөлт нь бүтээгдэхүүний борлуулалтын орлогын өсөлттэй харьцангуй өсөлт юм.

Өөрөөр хэлбэл санхүүгийн тайлант онд ашигт ажиллагааны түвшин урьд оноос 1,1-ээр буюу өсөлтийн коэффициент 1,4 хувиар өссөн нь чанарын үзүүлэлт юм.

2020 он бүхэлдээ цар тахалын хүндрэлтэй үед зардлыг зохих түвшинд барьж, орлогоо нэмэгдүүлж ажилласан амжилтыг цохон тэмдэглэхэд таатай байна.

Өөрөөр хэлвэл тайлант онд улсад орлогын татвараар 447,2 сая төгрөг төлсөн бөгөөд энэ нь урьд оноос 59,9 сая төгрөгөөр давуулсан байна.

Тайлант онд 3,483,2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, урьд оноос 639,9 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан бөгөөд өөрт үлдэх ашиг тайлант онд 3,035,9 сая төгрөгт хүрч урьд оноос 579,9 сая төгрөгөөр өссөн байгаа нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийг урьд оноос бууруулахгүй байх бодит бололцоог хангасан байна гэж үзэж байна.

3. Компанийн эргэлтийн хөрөнгө 18,385,0 сая төгрөгт хүрч урьд оноос 887,3 сая төгрөг болж өссөн байна. Эргэлтийн хөрөнгийн өсөлт нь материалын нөөц хангалттай байгааг харуулж байна. Үүнээс түргэн эргэх хөрөнгийн хэмжээ урьд оноос 249,8 сая төгрөгөөр буурсан боловч түргэн эргэх хөрөнгийн 954,4 сая байгаа нь төлбөрийн чадвар сайтай байгааг гэрчилж

байна. Эргэлтийн хөрөнгөнд томоохон байр суурь эзлэх материалын үлдэгдэл 2,442,4 төгрөгт хүрч урьд оноос 1,352,9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлт боловч энэ нь үйлдвэрлэлийн өдөр тутмын материалын хэрэгцээг хангах хүрэлцээтэй материалын үлдэгдэл юм.

4. Дансны бусдаас авах авлага тайлант онд 4,312,9 сая төгрөг болж урьд оноос 1,711,7 сая төгрөгөөр өссөн нь орлогын өсөлт, төлөвлөгөөний давуулалттай харьцангуй ойлголт боловч авлагын үлдэгдэл өссөн байгаад компанийн захиргаа судалгаа гаргаж, авлагыг тухай бүр барагдуулж байх шаардлагатайг анхааруулж байна.
5. Тайлант онд урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 3,267,8 сая төгрөг болж урьд оноос 3,189,3 сая төгрөгөөр буурчээ.
6. Дансны өглөг 9,969,8 сая төгрөгт хүрсэн нь урьд оноос 1,929,9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.

1. Тус компани 2020 онд нийт 3,483,2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, улсад орлогын татвараар 447,2 сая төгрөг төлж, өөрт үлдэх ашиг 3,035,9 сая төгрөгт хүрч урьд оныхоос 579,9 сая төгрөгөөр давуулж ажилласан нь хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хуваарилах нөхцөл бүрдсэн байна гэсэн дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгч байна.

2. Ногдол ашиг хуваарилалтын талаар :

Тус компани нь 1997 оны болон 2005-2019 онуудын ногдол ашгийг өөрийн компанийн тооцоогоор бэлэн мөнгөөр олгож байна. Зөвхөн 2020 онд ногдол ашигаас 127 хувьцаа эзэмшигчдэд 59,0 сая төгрөгийг хувиарлаад байна. Тус компани 7 хоног бүрийн Пүрэв гаригт ногдол ашгийг өөрийн компани дээрээ олгож байгаа бөгөөд ногдол ашгийн олголтыг он бүрээр нь Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөс тодорхойлж гаргасан тухайн онуудын тархалтын судалгаанд авагдсан хувьцаа эзэмшигч бүрийн овог нэр, регистрийн дугаар, харьяалагдаж байгаа брокерийн пүүсээр нь олгосон он, сар, өдрөөр нь тэмдэглэл хөтлөж олгож байна.

2020 онд тус компанийн борлуулалтын орлого, өөрт үлдэх ашиг болон түргэн эргэх мөнгөн хөрөнгийн хэмжээ өссөнөөр 2020 онд нэгж хувьцаанд 225 төгрөг хувиарлахаар ТУЗ-ийн тогтоол гаргаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал оруулж байна.

АУДИТЫН ХОРОО

“ТАЛХ ЧИХЭР” ХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЭДИЙН
ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

/ сая төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	2019 он	2020он	Дүн	Хувь
1.	Үндсэн ү/а-ны орлого	54855,8	63,054,2	+8252,3	+17,7%
2.	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	40885,6	47,695,2	+6,809,6	+16,7%
3.	Үйл ажиллагааны зардал	9424,4	10543,2	+1111,8	+11,8%
4.	Үндсэн ү/а-ны зардал	1702,5	1,332,4	-370,1	-21,7%
5.	Татвар төлөхийн өмнөх ашиг	2843,3	3483,2	+639,9	+22,5%
6.	Татварын орлогын зардал	387,3	447,2	+59,9	+15,4%
7.	Үлдэх ашиг	2456,0	3035,9	+579,9	+23,6%
8.	Эргэлтийн хөрөнгө	17497,9	18,385,0	+887,3	+5,1%
9.	Үүнээс түргэн эргэх хөрөнгө	1204,2	954,4	-249,8	-20,7%
10.	Бараа, мат-л,бэлэн бүт	3795,4	2442,5	-1352,9	-35,6%
11.	Урьдчилж төлсөн зардал	10,196,8	10954,0	+757,2	+7,4%
12.	Дансны авлага	2301,2	4012,9	+1711,7	+74,4%
13.	Дансны өглөг	8039,9	9969,8	+1929,9	+24,0%
14.	Урт хугацааны зээл	6457,1	3267,8	+4478,8	-49,4%
15.	Ашигт ажиллагааны түвшин	74,5	75,6	+1,1	+1,4%

АУДИТЫН ХОРОО